

## Сэлэнгэ аймгийн 2014 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн товч танилцуулга

### 1.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Сэлэнгэ аймгийн 2014 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг хангахад дараах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч ажиллалаа. Үүнд:

-Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөх өөрчлөлтүүд болон жилийн эцсийн тайлан гаргахад анхаарах асуудлаар 2 удаа төрийн сангийн төлөөлөгч нарын сургалт

-Төрийн сангийн болон төсөвт байгууллагуудад мөрдөж буй бүртгэлийн программ хангамжуудын өөрчлөлт программын сургалтыг зохион байгууллаа.

-Төрийн сангийн үйл ажиллагаа болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах зорилгоор Хушаат,Алтанбулаг,Шаамар, Сайхан сумдад санхүүгийн үйл ажиллагаанд тодорхой удирдамжийн дагуу шалгалт хийж газар дээр нь зөрчлийг арилгуулж ажиллалаа.

Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа сум болон шууд харьцдаг төсөвт байгууллагуудын 2014 оны эхний хагас жилийн тайлан, сумдын нэгтгэсэн тайланг нэгтгэн Сангийн яаманд тайлагналаа.

2014 оны эхний хагас жилд аймгийн орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нийт 17 сумын 97 төсөвт байгууллага, шууд харьцдаг 5 төсөвт байгууллага,ангилагдаагүй зардал,орон нутгийн болон замын сангийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт,орон нутгийн чанартай төсөл сангууд,орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газруудын санхүүгийн тайлан нэгтгэгдлээ.

2014 оны эхний хагас жилд орон нутгийн төсвийн орлогод 7212,8 сая төгрөгийн орлого орж 93,5 хувийн биелэлттэй гарсан байна.Мөн 2014 оны эхний хагас жилд Улсын төсвөөс 2574,8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг,3971,7 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийн санхүүжилт авч захиран зарцуулж ирлээ.Татварын орлогоос ХАОАТатвар,АТӨЯХАТ,Буу,Усны төлбөр,Ойгоос түлээ мод бэлтгэсний төлбөр,хөрөнгийн орлого,ТТАМАТөлбөр зэрэг орлогууд тасарсан байна.Ялангуяа ТТАМАТөлбөр 4,2 хувийн биелэлттэй гарсан нь орлого тасрахад гол нөлөө үзүүлсэн байна.

2014 оны эхний хагас жилд Орон нутгийн төсвийн зарлага 12909,4 сая төгрөг буюу 69,4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Төсвийн гүйцэтгэлд орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл хамрагдаж явж байгаатай холбоотойгоор төсвийн гүйцэтгэлийн биелэлтэнд гол нөлөө үзүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн санхүүжилт буюу орлогын шилжүүлгээр улсын төсвөөс эхний хагас жилд нийт 7492,4 сая төгрөг авахаас 3971,7 сая төгрөг авч 53,0 хувийн биелэлттэй гарсан нь зарлагын гүйцэтгэлд гол нөлөө үзүүлсэн байна.

2012 оны эхний хагас жилд орон нутгийн урсгал зардал 88 хувь, аймаг сумын хөрөнгө оруулалт 45,9 хувийн биелэлттэй гарсан байна. Нийт зардлын 70,5 хувийг урсгал зардалд,29,5 хувийг хөрөнгө оруулалтын зардалд зарцуулсан байна

Аймгийн орон нутгийн төсвийн төсөвт байгууллагууд 2014 оны эхний хагас жилд 97,2 сая төгрөгийн авлагатай, 53,8 сая төгрөгийн өглөгтэй болж урд оноос авлага 27,7 сая төгрөгөөр ,өглөг 22,6 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Нийт өглөгийн 20,6 сая төгрөг буюу 38,4 хувийг ажиллагсадтай холбогдсон цалин,нийгмийн даатгалын шимтгэлийн өр эзэлж байна.

## 2.ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2014оны эхний хагас жилл салбарын сайдуудтай байгуулсан гэрээний үндсэн дээр тусгай зориулалтын шилжүүлгээр нийт 5 сайдын 13 нэрийн байгууллагад 22958,2 сая төгрөгийн санхүүжилт авч захиран зарцуулж ирлээ.

Эхний хагас жилд төвлөрүүлэн захирагчийн тайланд нийт 17 сумын 130 төсвийн байгууллагын тайлан нэгтгэгдэж төсвийн гүйцэтгэлээр 21700,0 сая төгрөг зарцуулсан байна.Үүнд ЕБС 35,цэцэрлэг 34,хүн эмнэлэг 20,соёлын төв 19,театр чуулга 3,номын сан 2,музей 1,Биеийн тамир спорт хороо 6,хүүхдийн байгууллага 1,газрын алба 1,өрхийн эмнэлэг 7 байгууллага хамрагдсан байна.

Төсвийн зардал 94,5 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.Нийт зардлын 91,9 хувийг бараа үйлчилгээний зардалд,8,0 хувийг тусламж урамшууллын зардалд зарцуулсан байна.

2014 эхний хагас жилд шилжүүлгийн байгууллагууд нийт 28,8 сая төгрөгийн авлагатай, 210,3 сая төгрөгийн өглөгтэй ажилласан байна. Энэ нь авлага урд оноос авлага 1,6 сая төгрөгөөр буурч,өглөг 128,5 сая төгрөгөөр өссөн байна.Өглөгийн гол өсөлт нь халаалт, эм, цалингийн зардал дээр гарсан байна.

### Аймгийн нийт төсвийн гүйцэтгэл

| Үзүүлэлтүүд                      | төлөвлөгөө | гүйцэтгэл  | зөрүү      | хувь |
|----------------------------------|------------|------------|------------|------|
| Орон нутгийн төсвийн орлого      | 7712921,8  | 7212878,5  | -500043,3  | 93,5 |
| Орон нутгийн төсвийн зарлага     | 18585287,3 | 12909421,8 | -5675865,5 | 69,4 |
| Үүнээс хөрөнгө оруулалт          | 8299046,0  | 3812874,3  | -4486171,7 | 45,9 |
| Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг | 2574792,6  | 2574792,6  |            | 100  |
| Улсын төсвөөс орлогын шилжүүлэг  | 7492428,0  | 3971733,7  | -3520694,3 | 53,0 |
| ТЗШ-ийн санхүүжилт Үүнээс:       | 22958251,2 | 22958251,2 |            | 100  |
| • БШУСайд                        | 18835527,1 | 18835527,1 |            | 100  |
| • ЭМСайд                         | 2153259,5  | 2153259,5  |            | 100  |
| • ССАЖСайд                       | 1717678,1  | 1717678,1  |            | 100  |
| • БХБСайд                        | 105565,3   | 105565,3   |            | 100  |
| • ХАХНХСайд                      | 146221,2   | 146221,2   |            | 100  |

### Аймгийн төсвийн нийт авлага өглөг

|                                 | авлага   |          |          | өглөг    |          |           |
|---------------------------------|----------|----------|----------|----------|----------|-----------|
|                                 | 2013     | 2014,06  | зөрүү    | 2013     | 2014,06  | зөрүү     |
| Шилжүүлгийн төсөвт байгууллага  | 30375,4  | 28771,7  | -1603,7  | 81721,2  | 210292,2 | +128571,0 |
| Орон нутгийн төсөвт байгууллага | 124964,6 | 97167,9  | -27796,7 | 76284,4  | 53774,8  | -22509,6  |
| Нийт дүн                        | 155340,0 | 125939,6 | -29400,4 | 158005,6 | 264067,0 | -106061,4 |

### Шилжүүлгийн байгууллагын авлага өглөгийг салбараар харуулбал:

|           | авлага  |         |         | өглөг   |          |           |
|-----------|---------|---------|---------|---------|----------|-----------|
|           | 2013    | 2014,06 | зөрүү   | 2013    | 2014,06  | зөрүү     |
| БШУСайд   | 15706,2 | 19112,9 | +3406,7 | 48137,  | 85415,6  | +37278,6  |
| ЭМСайд    | 9462,6  | 5216,6  | -4246,0 | 25343,6 | 76504,2  | +51160,6  |
| ССАЖСайд  | 2116,6  | 2578,1  | +461,5  | 8147,9  | 48372,3  | 40224,4   |
| БХБСайд   | 2997,2  | 1864,0  | -1133,2 |         |          |           |
| ХАХНХСайд | 92,6    |         | -92,6   | 92,6    |          | -92,6     |
| Нийт дүн  | 30375,4 | 28771,7 | -1603,7 | 81721,2 | 210292,2 | +128571,0 |

### **3.ТӨСӨЛ САН, ОНӨУУГАЗАР**

2014 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд 10 орон нутгийн төсөл сан, 11 орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын тайлан нэгтгэгдсэн болно.

#### **Төсөл сан**

Нийт нэгтгэгдсэн төсөл сан нь 2631,3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, 8066,5 сая төгрөгийн авлагатай, 4,1 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 21,0 сая төгрөгийн өглөгтэй байна. Нийт авлагын 62,3 төгрөг АХСан, 3288,5 сая төгрөг ЖДҮДСан, 4648,4 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн авлага байна. Нийт өглөгийн 1,9 сая төгрөг Байгал хамгаалах сан, 18,8 сая төгрөг сум хөгжүүлэх сангийн өглөг байна.

#### **ОНӨУУГазар**

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд 11 үйлдвэрийн газар нэгтгэгдлээ. Үүнээс Үржлийн цөм сүргийн аж ахуй хагас жилийн тайлангаа гаргаж өгөөгүй болно.

Нийт үйлдвэрийн газар нь 148,6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, 2075,9 сая төгрөгийн авлагатай, 19570,2 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 5355,6 сая төгрөгийн өглөгтэй, 74,3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан дүнтэйгээр нэгтгэгдсэн байна.

Ерөнхий нягтлан бодогч М.Нарантуяа  
Холбоо барих утас 70363844